



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар

4/03

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх өвлөх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Батдоржийн Лхагвасүрэн (СУ86111670)-ийн хүсэлтийг судлан үзээд, иргэн Батдоржийн Лхагвабаатарын эзэмшилд байсан 2321002196 нэгж талбарын дугаартай Цэнхэрмандал сумын 1 дүгээр баг Хужхан, Эхэн толгойн доод хаягт байрлах, өвөлжөө, хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын, 2321002197 нэгж талбарын дугаартай, Цэнхэрмандал сумын 1 дүгээр баг Хужхан, Эхэн толгойн дээд хаягт байрлах, өвөлжөө, хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг тус тус иргэн Батдоржийн Лхагвасүрэнд шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан иргэн Б.Лхагвабаатарын эзэмшлийн 0000154385, 0000301042 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ